



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/176

Улаанбаатар хот

Хамгаалалтын зардал
гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны харъяа Москва хотын их сургуулийн адъюнктурт суралцаж байгаа Дамдинсүрэнгийн Гэрэлтбаатарын докторын зэрэг хамгаалах зардалд шаардагдаж буй 2500/Хоёр мянга таван зуун/ ам.долларын зардлыг Сургалтын төрийн сангаас санхүүжүүлсүгэй.

2.Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасгай.



Л.ГАНТӨМӨР